

**ХІ АНГИЙН ТҮҮХИЙН ХИЧЭЭЛИЙН БИЕ ДААН СУРАЛЦАХ АЖЛЫН ДЭВТЭР  
(АЖЛЫН ХУУДАС)**

Сурагчийн овог, нэр .....	Эхэлсэн он.... сар....өдөр.... цаг Дууссан он.... сар.... өдөр.... цаг
---------------------------	---

*“Бие даан суралцах ажлын дэвтэр”-т (ажлын хуудас) ажиллах сурагчдад өгөх зөвлөмж*

Энэхүү бие даан суралцах ажлын дэвтэр нь Түүхийн хичээлийн сургалтын хөтөлбөр, сурах бичигтэй агуулга, арга зүйн хувьд шууд холбоотой юм. Бие даан ажиллах дасгал, даалгаврыг гүйцэтгэснээр та сүүлийн 400 гаруй жилийн түүхээр аялж, өвөг дээдсийнхээ үлдээсэн амжилт, ололт, үлдээсэн туршлага, сургамжийн талаарх мэдлэг ойлголтоо бататгах боломжтой. Мөн бүх хичээлээр эзэмшдэг ерөнхий чадвараас гадна түүхийн тусгай чадваруудаа (Цаг тоолол хэрэглэх, шалтгаан үр дагаврыг олох г.м.) хөгжүүлэх, ХI ангийн агуулгыг нөхөж судлах, бие даан суралцах, өөрийн удирдлагатай суралцахад тань дэмжлэг болох болно.

Бие даан ажиллах, дасгал даалгавар тус бүрийг үндсэн 3 түвшинд хуваасан болно.

Тэмдэглэгээ	Тайлбар
<b>I</b> <b>II</b> <b>III</b>	Сэргээн санах, ойлголтын түвшний даалгавар
<b>I</b> <b>II</b> <b>III</b>	Хэрэглэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх түвшний даалгавар
<b>I</b> <b>II</b> <b>III</b>	Үнэлэх, бүтээх түвшний даалгавар

*Суралцахуйн зураглал*

Бүлэг сэдэв.	Түвшин		
	11-р анги I түвшин	11-р анги II түвшин	11-р анги III түвшин
Түүх судлах арга	1, 2, 3A,	3B, 3C, 3D,	4, 5,
Монголчуудын тусгаар тогтнол алдагдсан нь: Шалтгаан, үйл явц үр дагавар	1A, 5A,	1B, 2A, 5B	2B, 3A, 4, 6A, 6B
Монголчуудын тусгаар тогтнолын төлөөх тэмцэл	1, 2,	3A, 3B, 3C, 3D,4A, 5, 6	4B, 7
Монгол төрийн сэргэн мандалт	1A, 2	1B, 3, 4A, 4B, 5	6
1924-1990 оны БНМАУ-ын нийгэм, эдийн засаг, улс төрийн байдал			
Орчин үеийн Монгол Улс			

*Суралцахуйн зураглалтай ажиллах алхам*

I	Багшийн зөвлөсөн дасгал, даалгавруудаас эхлэн ажиллаарай.
II	Өөрийн хийж чаддаг болсон дасгал, даалгавруудыг тохирох түвшний өнгөөр будаарай.
III	Тухайн бүлгийн дасгал, даалагаврыг гүйцэтгэж эхэлсэн болон дуусгасан хугацааг заавал тэмдэглээрэй.
IV	Дасгал, даалгаврыг гүйцэтгэсний дараа өөрийгөө үнэлээрэй
V	Багшаараа үнэлүүлж, өгсөн зөвлөмжийн дагуу сайжруулаарай

## БҮЛЭГ СЭДЭВ: ТҮҮХИЙГ СУДЛАХ АРГА

### АГУУЛГЫН ХУРААНГУЙ

Анхдагч сурвалжуудыг шинжлэн судлах нь:

Түүх судлахын тулд анхдагч сурвалжуудыг өөрсдийг нь магадлан шалгаснаар эхэлнэ. Сурвалжийн хуулбарууд түүхчийг төөрөгдүүлдэг. Сурвалжууд анхдагч байлаа ч гэсэн зохиогч нь зориуд бодит байдлыг гуйвуулан бичсэн юм уу, санамсаргүйгээр алдаа мадаг гаргасан сурвалжууд ч олон тохиолдоно. Зарим тохиолдолд дан ганц сурвалж ч биш, түүхчид өөрсдөө тухайн баримтад туссан үзэл санааг ойлгоогүйгээс болж алдаа мадаг гаргаж болдог. Тиймээс сурвалжийн судалгааг эхлүүлэхийн тулд юуны түрүүнд хэд хэдэн асуултуудыг тавьдаг.

- Ямар сурвалж вэ?
- Хэн үүнийг бичсэн бэ?
- Хэнд, яагаад зориулан бүтээв?
- Хаана хэзээ бүтээв?

Аливаа сурвалжийн шинж чанарыг мэдсэнээр түүхч тухайн сурвалжаас чухам ямар төрлийн мэдээлэл олж авч болох вэ гэдгийг амархан ойлгож болдог. Түүхчийн асуухыг хүссэн асуултуудад сурвалжууд тэр бүр шууд хариулт өгөөд байдаггүй тул сурвалжийг шүүмжлэлтэйгээр гадаад, дотоод талаас нь нарийн тодорхой судлах шаардлагатай байдаг.

*Дэлгэржаргал, П. нар (ред) МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ. Улаанбаатар 2017, МУИС ПРЕСС*

#### 1. Бие дааж ажиллах дасгал, даалгавар

I II III

Түүх судлах аргатай холбоотой тулгуур ойлголтуудын ашиглан өгүүлбэрийг нөхнө үү?

Анхдагч сурвалж Хоёрдогч сурвалж Бичмэл сурвалж  
Эд өлгийн сурвалж Аман сурвалж Зохиомол

Анхдагч сурвалжуудыг уншиж судлалгүйгээр түүхийг хэн ч ойлгож чадахгүй. Энгийнээр тодорхойлбол (1) \_\_\_\_\_ гэдэг бол тухайн судалж буй үйл явдал, түүхэн цаг үед бүтээгдсэн юмуу, тэрхүү цаг үеэс арай хожуухан бүтээгдсэн байдаг.

Харин ном, өгүүлэл, баримтат юм уу, уран сайхны кино зэрэг (2) \_\_\_\_\_ нь судлагдаж, тодорхойлогдож буй үйл явдлын дараа, нэлээд хожуу бүтээгдсэнээрээ анхдагч сурвалжаас ялгаатай. Ихэнх анхдагч сурвалжууд нь засгийн газрын тогтоол, шийдвэр, хууль эрхзүйн баримт бичиг, хувийн захидал, тэмдэглэл, худалдаачны данс, тооцоо, гэхмэтчилэн (3) \_\_\_\_\_ байдаг. Хоёрдогч сурвалж нь сайн, муу бичигдсэн байхаас үл хамааран анхдагч сурвалжуудад тулгуурлаж, анхдагч сурвалжуудаас үүдэлтэй байдаг тул ямагт (4) \_\_\_\_\_ буюу хоёрдогч шинж чанараа хадгалж байдаг. Түүхийг судлахад бичмэл сурвалжаас гадна аман уламжлалын юм уу (5) \_\_\_\_\_ ашигладаг. (6) \_\_\_\_\_ гэдэгт домог үлгэр, шившлэг дуудлага, хэлц үгс, олон янзын билиг сургаал багтана. Эдгээрийг нийтэд нь аман хэлбэрээр дамжин тархаж нийгмийн он санамжид үлдсэн өнгөрсний ул мөр гэж ойлгож болно.

#### 2. Бие дааж ажиллах дасгал, даалгавар

I II III

Түүхийн хавсрага ухаануудыг зөв тохируулж, хүснэгтэд тэмдэглэнэ үү.

1	Нумизматик	А	Овог төрлийн харилцааны түүх судлал
2	Генелог	Б	Албан баримт бичиг судлал
3	Дипломатик	В	Бичээс судлал
4	Геральдик	Г	Тамга судлал
5	Сигилиграфи	Д	Сүлд судлал
6	Эпиграфи	Е	Зоос, мөнгө судлал

1	2	3	4	5	6

3. *Бие дааж ажиллах дасгал, даалгавар*

А. XVII – XVIII, XIX – XX зууны Монголын түүхийн гол үйл явдлуудыг нэрлэж бичнэ үү.

XVII-XVIII зуун	XIX-XX зуун

В. Дараах хоёр судлаачдын үгэнд тулгуурлан түүх судлахын ач холбогдлыг тодорхойлно уу.

- Жорж Сантаяна “Өнгөрснийг мартагсад түүнийг давтах тавилантай”.
- Е. М. Жуков “Түүхийн шинжлэх ухаан нь үечлэлгүйгээр оршин тогтнож үл чадна”

---



---



---



---



---




---



---

С. XX зууны тусгаар тогтнолтой холбогдох гол үйл явдлуудаас амжилт, ололттой гэж дүгнэсэн үйл явдлыг дээд талын хүснэгтэд, алдаа дутагдалтай гэж дүгнэсэн үйл явдлыг доод талын хүснэгтэд тэмдэглэнэ үү.



D. Дээр тэмдэглэсэн үйл явдлуудаасаа амжилт, ололттой үйл явдал, алдаа дутагдалтай үйл явдал тус бүр нэг нэгийг сонгон авч, ач холбогдол, сургамжийг тодорхойлно уу.

I	II	III
---	----	-----

Үйл явдал 1	
Ач холбогдол	Сургамж
Үйл явдал 2	
Ач холбогдол	Сургамж

I	II	III
---	----	-----

4. Бие дааж ажиллах дасгал, даалгавар  
XVII-XX зууны Монголын нийгмийн дүр төрх, ард түмний аж амьдралын талаар өөрийн мэдлэг ойлголт дээрээ үндэслэн хэрхэн тайлбарлах вэ?

---



---



---



---



---



---

---

---

---

---

---

5. Бие дааж ажиллах дасгал, даалгавар



<p>Сурвалжийн үнэн, бодитой эсэхийг магадлахдаа ямар зарчмыг баримтлах вэ?</p>	<hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/>
--	---

Бие даан судлах боломжтой хэрэглэгдэхүүн

- ❖ Теле хичээл – Түүх судлах арга <http://econtent.edu.mn/lessons/EBS/11rangj/tuuh/2992>
- ❖ Ц. Гантулга нар, Монголын түүх XI сурах бичиг, 5-р тал

**БҮЛЭГ СЭДЭВ: МОНГОЛЧУУДЫН ТУСГААР ТОГТНОЛ АЛДАГДСАН НЬ: ШАЛТГААН, ҮЙЛ ЯВЦ,  
ҮР ДАГАВАР**

Сурагчийн овог, нэр .....	Эхэлсэн он.... сар....өдөр.... цаг Дууссан он.... сар.... өдөр.... цаг
---------------------------	---

**АГУУЛГЫН ХУРААНГУЙ**

XVII-XVIII зуун бол монголчууд тусгаар тогтнолоо алдаж, харийн эрхшээлд байсан үе юм. XVII зууны эхэн үед Монголчууд Халх (Халх Монгол), Өмнөд Монгол (Өвөр Монгол), Ойрад (Баруун Монгол) гурван том хэсгээс бүрдэж байв. Халх Монгол гурван том аймгаас (Түшээт хан, Засагт хан, Сэцэн хан) бүрдэж байсан бол, Өмнөд Монгол нь Цахар, Хорчин, Түмэд, Юншээбү, Ордос, Асуд, Найман, Жаруд, Авга зэрэг 16-н аймагтай байв. Ойрадын дотроос Цорос, Торгууд, Хошууд, Дөрвөд, Хойд аймаг бусдаасаа илүү нөлөөтэй байжээ. Энэ үед Ойрадын их нүүдэл хийх явдал бий болж, Торгууд аймаг, Дөрвөдийн зарим хэсэг баруун хойд зүг Ижил мөрөн рүү, Хошууд аймаг зүүн урагш Хөх нуурын зүг тус тус нүүдэллэжээ. Чингис хааны угсааны Монголын сүүлчийн их хаан Лигдэн хутагт (1604-1634) баруун, зүүн түмнийг нэгтгэн захирч, дотоодын хямралыг зогсоох, Мин улстай цэргийн холбоо тогтоох замаар Манжийн түрэмгийллийн эсрэг тэмцэх бодлого баримталж байжээ. Өмнөд Монголд Лигдэн хааны төвлөрсөн засгийн бодлогод дургүйцсэн салан тусгаарлах хөдөлгөөн хүчтэй байсан бөгөөд их хаан бусад аймаг, улсуудын биеэ даан салан тусгаарлах үйл ажиллагааг *төрөөс этгээд явдал* гэж үзжээ. XVII зууны үед Монголын ноёд язгууртнууд нэгдмэл бус бие даахын төлөө байв. Энэ нь хэд хэдэн шалтгаантай байв. Тухайлбал, үзэл санаа, нийгэм, эдийн засгийн байдал, газарзүйн байршил, гадаад дотоод нөхцөл байдал гэх мэт. Манжийн төрийн бодлогын зэрэгцээ Хаант Орос улс баруун Сибирийн газар нутгийн ихэнхийг эзлээд Эрчис гол, дорнод Сибирь, Байгаль нуур хавийн нутаг руу давших болжээ.

**1. Бие дааж ажиллах дасгал, даалгавар**



**A.** Тухайн үеийн түүхийн гол нэр томъёо, ойлголт, үйл явдлыг тайлбарлана уу.

Нэр томъёо, ойлголт	Тайлбар
Төрөөс этгээд явдал	-
Буурын гэрээ	-
Халимаг	-
Нүүдэлчдийг нүүдэлчдээр нь цохиулах	-
Халх-Ойрадын их цааз	-
Зүүнгарын улс	-
Долоон нуурын чуулган	-
Заг байдрагийн Хүрэн бэлчирийн чуулган	-

В. Дээрх түүхийн гол нэр томьёо, ойлголт, үйл явдлаас сонгон авч шалтгаан, үр дагаврыг тодорхойлно уу.

I II III

Түүхийн нэр томьёо, ойлголт	Шалтгаан	Үр дагавар
1.		
2.		

2. Бие дааж ажиллах дасгал, даалгавар

I II III

А. XVII-XVIII зууны үеийн Монголын түүхэнд холбогдох түүхэн хүмүүсийг нэрлэж, тухайн хүнийг өгүүлбэрээр илэрхийлнэ үү.



А.	Б.	В.
----	----	----



Г.	Д.	Е.
----	----	----







Сурвалж 2.

Лигдэн хааны 1619 онд Нурхачид илгээсэн бичиг “Дөчин түмэн Монголын эзэн баатар Чингис хааны зарлиг. Усны гурван түмэн Манжийн эзэн Хөндлөн гэгээн хаан мэнд буюу. Хятад улс бид хоёр лугаа эртнээс өшөөт бөлгөө. Морин жилээс инагш Хятад улсыг зовоохуй чинь сонслоо. Энэ хонин жилийн зун би биеэрээ морилж Хятадын Гуаннин хотыг оруулж алба авлаа. Эдүгээ чи Гуаннингийн хотод цэрэг морилвоос би чамайг саад хиймүү. Бид хоёр дайсан үгүй болов. Оруулсан улсаа чамд автвас нэр минь ямар болму. Энэ үгийг минь эвдвээс бид хоёрын зөв бурууг дээр тэнгэр нэр ялгаж мэднэм зэ...  
(Манжийн үнэн магад хууль, 2009:78 )

Сурвалж 3.

Манжийн Нурхач 1620 онд Лигдэн хааны тулган шаардах бичгийн хариу “...гурван түмэн улс үгүй бөгөөтөл дөчин түмэн хэмээн эртний үгээр омгорхон, улсыг минь цөөн гурван түмэн хэмээн доромжлохыг тэнгэр мэднэм зэ... тэнгэр газарт ивээгдэх өлзий хутгийг үйл үйлдэн их нэр төрийг үл сэтгэн, эд таваарт хурьцаж, гэмгүй явах харь улсын хааныг доромжлон муу сэтгэж явахуйг чинь тэнгэр газар үл мэдэх буюу...”  
(Манжийн үнэн магад хууль, 2009:78 )

Сурвалж 4.

“... Бичиг барихын учир: Хаан хүмүүнд хас их төр, хамагт сонсдох сайн алдар нэр хэрэгтэй тул хамгаас төр шашныг мандуулах нэрийг эрэлдье. Зургаан түмний эзэн биднийг жолоодон эс чадав. Тэр эс чадавч хан төрөлт бидэн ... хас их төрийг хадгалж суунам бид. Энэ их төрийг санахул нь нааш цааш элч юугаан тасралтгүй мэнд асуулцаж явья. Ийн хийж явахул эрдэнэт хүмүүний төрөл олж эрх хүчит хан болон төрсний гавьяа тэр ажааму”.

(Халхын ноёдоос Манжийн хаанд илгээсэн бичгээс)

Асуулт 1. Сурвалж 1 болон өөрийн мэдлэгт тулгуурлан XVII зууны үеийн Монголчууд хэрхэн хуваагдан аж төрж байсан болон, хаагуур нутаглаж байсныг тайлбарлана уу.

---

---

---

---

---

---

---

---

Асуулт 2. Сурвалж 2, 3 болон агуулгын хураангуй мэдээлэлд тулгуурлан Лигдэн хааны улс төрийн бодлого, үйл ажиллагааг тодорхойлно уу.

---

---

---

---

---

---

---

---

---

---



5. Бие дааж ажиллах дасгал, даалгавар

А. Өвөр Монгол, Халх Монгол, Хөх нуурын Монгол, Зүүнгарын хаант улс ээлж дараалан Манжийн эрхшээлд орсныг холбогдох үзүүлэлтийн дагуу тодорхойлно уу.

Үзүүлэлт	Өвөр Монгол	Халх Монгол	Хөх нуурын Монгол	Зүүнгарын хаант улс
Түүхэн зүтгэлтнүүд	<i>Нурхач, Лигдэн</i>		<i>Гүүш хан Төрбайх, Даян, Дашбаатар, Цэрэндондов, Лувсанданзан</i>	
Манжийн бодлого	<i>Цол, хэргэм, бэлэг сэлт, шан харамж</i>			
Шалтгаан	<i>Лигдэн хааны бодлого, Монголчуудын зөрчил, Төрөөс этгээд явдал г.м</i>			<i>Халх-Ойрадын дайн, Монгол ноёдуудын урвалт г.м.</i>
Гол үйл явдал	<i>Лигдэн хаан нас барсан.</i>		<i>Манжид дагаар орсон.</i>	
Түүхэн сургамж				

В. Бие дааж ажиллах дасгал, даалгаврын гүйцэтгэл дээрээ тулгуурлан гүйцэтгэнэ үү?




<p>Манжийн төр Монголчуудын эрхшээлдээ оруулахын тулд ямар ямар бодлогууд явуулж байсан бэ?</p>	<p>- - - - - -</p>
<p>Таны нэрлэсэн бодлогуудаас хамгийн үр дүнтэй хэрэгжсэн бодлого аль нь вэ? Яагаад</p>	
<p>Монголчууд Манжийн болон Оросын түрэмгийллийн эсрэг хэрхэн тэмцэж байсныг тодорхой баримтад үндэслэн тайлбарлана уу.</p>	
<p>Монголчууд харийн эрхшээл, нөлөөнд орсны нийтлэг шалтгааныг та хэрхэн дүгнэж байна вэ?</p>	


6. Бие дааж ажиллах, дасгал даалгавар

А. Газар зүйн зургуудыг ажиглаж, Буриад болон Халимагийн тухайн үеийн нутаг дэвсгэрийг тодорхойлж, одоогийн ОХУ-ын газар зүйн зурагт тэмдэглэнэ үү.

Газар зүйн зураг 1.



Калмыцкое ханство в 1730-е - 1771 гг.



Газар зүйн зураг 3.



В. Торгуудын их нүүдлийн шалтгаан, үр дагавар, сургамжийг тодорхойлно уу.

---



---



---



---



---

Бие даан судлах боломжтой хэрэглэгдэхүүн

- ❖ Торгуудын их нүүдлийн тухай Калмык баримтат кино. <https://www.youtube.com/watch?v=EfpVrTRbdwE>
- ❖ Теле хичээл <http://econtent.edu.mn/lessons/EBS/11rangji/tuuu/3252>
- ❖ Манжийн ноёрхлын үеийн Ар, Өвөр Монгол <https://www.youtube.com/watch?v=KEggXYHyh0>

**БҮЛЭГ СЭДЭВ: МОНГОЛЧУУДЫН ТУСГААР ТОГТНОЛЫН ТӨЛӨӨХ ТЭМЦЭЛ,  
ХӨДӨЛГӨӨН**

Сурагчийн овог, нэр .....	Эхэлсэн он.... сар....өдөр.... цаг Дууссан он.... сар.... өдөр.... цаг
---------------------------	---

**АГУУЛГЫН ХУРААНГУЙ**

XVII-XVIII зууны Монголын тусгаар тогтнолын тэмцлийн дотроос хамгийн далайцтай нь 1755-1758 онд гарсан бослого юм. Тэрхүү бослогыг Зүүнгарын Амарсанаа, Хотгойдын чин ван Чингүнжав нар удирджээ. Баруун Монгол, Халх Монгол, Өвөр Монголын нөлөө бүхий ноёд тусгаар тогтнолын тэмцлийг зохион байгуулах, удирдан явуулахад идэвхийлэн оролцох болсон нь манжийн ноёрхлыг монголчууд хичнээн дургүйцэн жигшиж, эх орныхоо тусгаар тогтнолын үйл хэргийг хичнээн эрхэмлэж байсныг харуулна.

1755-1758 оны Манжийг эсэргүүцсэн зэвсэгт бослого тэмцлийн үйл явцад Өвөр Монголын зарим ноёд мөн оролцжээ. XIX зууны дунд үеэс бослого тэмцэл удаа дараа гарах болсон нь Манж Чин улсын дарангуйлал, нутгийн ноёд, хятадын мөнгө хүүлэгч, худалдаачдын мөлжлөг, хятад иргэд нутаг бэлчээр булаан эзэмшиж тариа тарин суурьших болсон зэрэгтэй холбоотой байв. 1858, 1905-1907 онд Ордосын хошуудад гарсан дугуйлангийн хөдөлгөөнд оролцогсад болзоот газар цугларч, дугуйран суугаад эрх баригчидтай тэмцэх аргаа хэлэлцэн тогтдог байв.

<b>I</b>	<b>II</b>	<b>III</b>
----------	-----------	------------

**1. Бие дааж ажиллах дасгал, даалгавар**

Манжийн жанжин, сайдын газруудын тохирох хувилбарыг өгөгдсөн өгүүлбэрт тэмдэглэнэ үү.

<i>Ховдын сайдын газар</i>	<i>Хүрээ сайдын газар</i>
<i>Улиастайн жанжны газар</i>	<i>Гадаад Монголын Төрийг засах Явдлын Яам</i>

- a) Манж Чин улсын монголчуудыг захирах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэгч гол байгууллага бол Монгол журган буюу \_\_\_\_\_ юм.
- b) \_\_\_\_\_ нь Ар Монголын цэргийн хэргийг ерөнхийлөн захирах хамгийн том газар байв.
- c) \_\_\_\_\_ нь Манж Чин улсаас Ар Монголд байгуулсан засаг захиргааны томоохон газрын нэг бөгөөд Халхын зүүн хоёр аймаг буюу Түшээт хан аймаг, Сэцэн хан аймаг болон Их шавь, эдгээр нутаг дахь өртөө, харуулын хэргийг харьяалан захирч байв.
- d) \_\_\_\_\_ нь Дөрвөдийн баруун, зүүн гарын 2 аймаг, Алтайн Урианхайн баруун, зүүн гарын 7 хошуу, торгууд, мянгад, захчин, өөлдийн нэг хошуу болон эдгээр газар дахь албан харуул, өртөө, хятад тариачдын хэргийг эрхлэн хариуцаж байжээ.

**2. Бие дааж ажиллах дасгал, даалгавар**

Дараах нэр томъёо ойлголтыг тайлбарлана уу.


<b>I</b>	<b>II</b>	<b>III</b>
----------	-----------	------------

Аймгийн чуулган	-
Засаг ноён	-
Хошуу	-
Сум ард	-
Тамгатай хутагт	-

3. Бие дааж ажиллах дасгал, даалгавар

А. Түүхэн зургуудыг ажиглаж, түүхэн зүтгэлтнүүдийг нэрлэнэ үү.

А..... Б..... В..... Г.....



В. Дээрх түүхэн зүтгэлтнүүднүүдийн тэмцлийн хэлбэр, үйл явц, үр дүнгийн тухай та юу мэдэх вэ?

Түүхэн зүтгэлтэн	Тэмцлийн хэлбэр	Үйл явц	Үр дүн
А.....			
Б.....			
В.....			
Г.....			



C. Манжийн эсрэг Монголчууд тэмцлийн ямар ямар хэлбэрүүдийг ашиглаж байв. Аль зуунд ямар тэмцлийн хэлбэрүүд илүү хамаарах вэ?

XVII-XVIII зуун	XIX-XX зуун
-	-
-	-
-	-
-	-
-	-

D. Эдгээр тэмцэл, хөдөлгөөнүүдийн сургамжтай талыг та хэрхэн дүгнэх вэ?

---



---



---



---



---



---



---



---



---



---

4. Бие дааж ажиллах дасгал, даалгавар

A. XX зууны эхэнд Манж Чин улс ямар аргаар хэрхэн Монголчуудыг эрхшээлдээ барьж байсныг өгөгдсөн хүснэгтийг ашиглан тайлбарлана уу.

Манж Чин улсын төрөөс Монголчуудыг эрхшээлдээ барьж байсан аргууд		
Улс төр	Эдийн засгийн хувьд	Оюун санааны хувьд



6. Бие дааж ажиллах дасгал, даалгавар

Сурвалжуудыг сайтар уншиж асуултад хариулна уу.

Сурвалж 1.

- Энэ удаа цэрэг орох нь тусгайлан олон Өөлд хулгайг, хядаж, сөнөлгөхийн тулд буюу... хулгай нарыг барих, хядах учир цэрэг авч чадах чинээгээр нэгжин хядвал зохино. ойр дотны махчин нарыг хамтаар хядтугай, хулгайг нэг хэмээн бүү үлдээ. (*“Зүүнгарын бодлогын бичиг”*. Жинхэнэ зохиол. 48-р дэвтэр)

Сурвалж 2.

- Түүнийг ширүүн тулалдаанд дайснаа дарж хүч хүрэлгүй Монгол нутгаасаа гарч, Оросын зүг тусламж гуйхаар одсон бөгөөд явахынхаа өмнө тал нутаг, уул, ус ард түмэндээ дахин буцаж ирнэ гэж тангарагласан. (Амарсанаагийн тухай домог яриа)

Сурвалж 3.

- Босогчид Манжийн цэрэг, өртөө харуулын албыг хаях, зарим өртөө, харуул болон хятад худалдаачдыг довтлон цохих хийгээд Манжийн цэрэгтэй шууд тулалдан байлдах зэрэг тэмцлийн арга хэлбэрийг хэрэглэж байжээ. (Монгол Улсын түүх Дөтгөөр боть.УБ.,2003)


Сурвалж 4.

- Халхаас тийнхүү цэргийн бэлтгэлд зориулж дайчлан татсан адуу 150 000, тэмээ 221 100, үхэр 22 300, хонь 469 000 гаруйг XVIII зууны дундуур Манж нар мөнхүү Халхын ардуудаар үнэ хөлсгүйгээр хариулгаж байжээ.

Сурвалж 5.

- Манжийн хаан Өөлд монголчуудтай дайныг нөрж, цэргийн хэрэглэлд Халхчуудыг зовоон, мал зүйлийг дайчилж, зүйл зүйлээр зүдүүлж, бас Чингисийн угсааны ван Ринчиндоржийг яллан, хилсээр үхүүлсэн зэрэг учрыг гаргаж, даруй хүчийг хамтатган, Манжийн хаанаас салбал зохино. Хэрэв үүнийг дагахгүй бол цэргийн хүчээр Халхчуудыг хамгаалан авна” (*Б.Буянчуулган. «Дөрвөн Ойрадын түүх»*. Өөлдийн Амарсанаа хааны бүлэг. тал 231.

Сурвалж 6.



Асуулт 1. Халх Монгол нь Манж Чин улстай Зүүнгарын хаант улсаас илүү найрсаг харилцаатай байж чадсан уу.

---

---

---

---

---

---

Асуулт 2. Сурвалж 2-н мэдээ тухайн үеийн ард түмний хүсэл зоригийг тодорхойлод нэмэр болж чадах уу.

---

---

---

---

Асуулт 3. Сурвалж 3, 4 монголчуудын манжийн эсрэг тэмцлийн талаар ямар мэдээлэл өгч байна вэ?

---

---

---

---

---

---

Асуулт 4. Сурвалж 6-д тулгуурлан Монголчуудаас Манжийн төрд залгуулж өртөөний албаны талаар тайлбарлана уу.

---

---

---

---

---

Асуулт 5. Сурвалжуудын мэдээнүүдийг холбон шинжилж, Манжийн эсрэг тэмцэл, хөдөлгөөний түүхэн ач холбогдол, алдаа оноог дүгнэж бичнэ үү.

7. Бие дааж ажиллах дасгал, даалгавар

Дараах эрдэмтэн судлаачдын үзэл санаа байр суурийг сайтар уншиж даалгаврыг гүйцэтгэнэ үү.

- Монголын эрдэмтэн судлаачдын бүтээлд Манжийн эрхшээлийн үеийн Монгол орны статусын тухай асуудлыг авч үзсэн дараах гурван хандлага байна.

Нэг. Монгол орон Манжийн колони улс байв.	<p>Энэ талаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Л. Дэндэв "... 1691 онд Долон нуурт болсон чуулган дээр Манжийн хаан нь Халхыг өөрийн албат болгож авав... энэ үеэс Монголын улс хэмээх байхгүй болоод ард түмэн нь колони үндэсний дарлалд нэрвэгдэж байв"</li> <li>- Ц. Насанбалжир "1691 онд ... Халх монгол манжийн феодал, түрэмгийлэгчдийн дур зоргоороо ноёрхох колонийн орон болж, Манж Чин улсын хоцрогдсон алс бөглүү хязгаар, умард зүгийн харуул цагдаа халхавчийн төдий газар болон хувирчээ"</li> <li>- Ш. Сандаг "Халхын хар, шар феодалууд эх орноосоо урваж, Манжийн түрэмгийлэгчдэд төрөлх нутаг, ард түмнээ худалдсаар... Халх Монгол улс төрийнхөө тусгаар тогтнолыг алдаад ... манж гүрний зах хязгаарын халхавч болсон колони орон..."</li> </ul>
Хоёр. Монгол нь Манжийн "Доминион" байсан.	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Ерөнхийлөч асан П. Очирбат "Монгол Улс тусгаар тогтнолоо алдан устаж, Манжид эзлэгдээгүй, 1691-1911 он хүртэл 220 орчим жил харьцангуй бие даасан байдлаа хадгалан, Манж Чин улсын нэг ёсны доминион байсан"</li> <li>- Судлаач Д.Мөнх-Очир, Ч. Болдбаатар нар "Түүхэн баримт, үйл явдлуудаас үзэхэд колони байсан гэж үзэх үндэслэл онолын түвшинд алга байна"</li> </ul>
Гурав. Монгол Манжийн хараат улс байв.	<ul style="list-style-type: none"> <li>- Ш. Нацагдорж "Монгол нь Манжийн хараат вассал болсон" гэсэн үзэл санааг дэвшүүлсэн</li> <li>- Д. Гонгор "Халхын хаант улс...Монголын тулгар төр улсын байр суурийг улбаадан хадгалж яваад 1691 онд Манжийн хараат болж тусгаар тогтнолоо алджээ"</li> <li>- Ж. Болдбаатар "Манжийн эрхшээлийн үеийн Монголын статус квог тогтоохын тулд хараат түшмэг юмуу, колони байсан гэх зэргээр бүдүүвчлэх биш, нарийвчилсан шалгуур тогтоох үндсэн дээр үечлэн үзэж, түүхийн үнэнийг сэргээхийг эрмэлзэх хэрэгтэй" гэж үзжээ.</li> </ul>

А. Эрдэмтэн судлаачдын үзэл санаа, байр суурийн ижил болон ялгаатай талуудыг та хэрхэн тодорхойлох вэ?

Ижил тал	Ялгаатай талууд
_____	_____
_____	_____
_____	_____
_____	_____
_____	_____
_____	_____
_____	_____
_____	_____
_____	_____
_____	_____

В. Эрдэмтэн судлаачдын үзэл санаа, байр сууриас аль хувилбартай нь та илүү санал нийлж байна вэ? Яагаад

---

---

---

---

---

---

---

---

С. Өөрийн мэдлэг болон судлаачдын үзэл санаа, байр суурьт тулгуурлан та хэрхэн тайлбарлах вэ?

---

---

---

---

---

---

---

---

Бие даан судлах боломжтой хэрэглэгдэхүүн

- ❖ Тогтох тайж <https://www.youtube.com/watch?v=ucYZvh9a-5c>
- ❖ Д. Өлзийбаатар 1755-1758 Зэвсэгт бослого <https://www.youtube.com/watch?v=yXAd5ulfqYk>
- ❖ Галдан бошигт хаан <https://www.youtube.com/watch?v=nOOX20hfomM>



## БҮЛЭГ СЭДЭВ: МОНГОЛ ТӨРИЙН СЭРГЭН МАНДАЛТ

### АГУУЛГЫН ХУРААНГУЙ

Манж Чин улс Монгол орныг гадаад ертөнцөөс битүүмжлэн хязгаарлан барьж байх бодлогоо өөрчлөх болсон нь хэд хэдэн шалтгаантай байлаа. Тухайлбал, XIX зууны дунд үе гэхэд Манж Чин улс харийн түрэмгийлэлд өртөх болж улмаар Өрнөдийн гүрнүүдийн тулгасан эрх тэгш бус гэрээ хэлэлцээрийг хүчин мөхөсдөн хүлээн зөвшөөрснөөр өөрөө колони орон болон мөлжигдөх болсон байв. Чин улсын дэглэмийг эсэргүүцсэн олон түмний тэмцэл тасралтгүй гарах болов. Чин гүрний төрийн бодлого өөрчлөгдөж, “Шинэ засгийн бодлого” хэрэгжүүлж эхэлсэн нь угаасаа харийн эрхшээлийг үзэн ядаж байсан монголчуудад нэрмээс болов. Чин гүрнээс салан тусгаарлахыг хүссэн олон монголчуудыг тэмцлийг удирдан зохион байгуулах хүчин болсон Чингисийн алтан ургийн ноёд, ихэс лам нар зэрэг үндэсний дэвшилт хүчнүүд нэгдэн нягтрах үйл явц нэлээд хэдэн жил үргэлжилжээ. Тэд Өвөр монгол, Хөх нуур, Барга, Алашаа зэрэг бүх монголчууддаа хандан тусгаар улс байгуулах болсныг зарлан мэдэгдэв. 1911 оны 12 сарын 29-нд VIII Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын шашин, төрийг хослон баригч, наран гэрэлт Богд хаанаар өргөмжилжээ. Төрийн 5 яамыг байгуулан, оны цолыг Олноо Өргөгдсөн хэмээн тогтож, Их Хүрээг Нийслэл Хүрээ гэж нэрлэв. Ийнхүү Монгол Улс дахин сэргэн мандаж, дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн туурга тусгаар тур улс болон тогтнон хөгжих эхлэл тавигдсан билээ.

### 1. Бие дааж ажиллах дасгал, даалгавар

А. 1911, 1921 оны хувьсгалд холбогдох түүхэн зүтгэлтнүүдийн түүхэн зургуудыг нэрлэж, доор хүснэгтэд ангилж бичнэ үү.



А. ....



Б. ....



В. ....



Г. ....



Д. ....



Е. ....



Ё. ....

Ж. ....

З. ....





1911 оны хувьсгалд холбогдох түүхэн зүтгэлтэн	1921 оны хувьсгалд холбогдох түүхэн зүтгэлтэн

В. Дээрх түүхэн зүтгэлтнүүдээс 1911, 1921 оны хувьсгалд холбогдох тус бүр нэг түүхэн зүтгэлтний сонгон авч намтар, үйл ажиллагааг зэрэгцүүлэн шинжлэн судалж үр дүнг бичнэ үү. Зэрэгцүүлэн шинжлэхдээ дараах загварыг ашиглаж болно. Үүнд:

- Гарал угсаа
- Гол үйл ажиллагаа
- Эрхэлж байсан албан тушаал
- Улс төрийн байр суурь
- Нийгмийн нөхцөл байдал
- Нас барсан шалтгаан г.м

1911 оны хувьсгалд холбогдох түүхэн зүтгэлтэн	1921 оны хувьсгалд холбогдох түүхэн зүтгэлтэн

2. *Бие дааж ажиллах дасгал, даалгавар*  
Дараах түүхийн нэр томьёо, тулгуур ойлголтуудыг тайлбарлана уу.  
Олноо өргөгдсөн он.....

I	II	III
---	----	-----

Де факто .....

Улсын дээд, доод хурал.....

Автономит эрх .....


Коминтерн.....

Тангарагийн гэрээ.....

3. *Бие дааж ажиллах дасгал, даалгавар*

I	II	III
---	----	-----

А. 1911-1921 хооронд болсон үйл явдлуудын ололт амжилт дээш чиглэсэн суманд шулуунд, алдаа дутагдлыг доош чиглэсэн шулуунд хүснэгтэлж, тэмдэглэнэ үү.



В. Тэмдэгсэн үйл явдлаасаа 1911, 1921 онд холбогдох тус бүр 1 үйл явдлыг сонгон авч шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг тайлбарлана уу.

I	II	III
---	----	-----

---

---

---

---

---

---

4. Бие дааж ажиллах дасгал, даалгавар



А. 1911, 1921 оны хувьсгалуудыг холбогдох үзүүлэлтийн дагуу харьцуулна уу.

Үзүүлэлт	1911	1921
Удирдагчид		
Хувьсгалын өмнөх нөхцөл байдал		
Гол үйл явдал		
Шинж чанар		
Ач холбогдол		
Хувьсгалыг удирдсан байгууллага		
Хувьсгалын шийдвэрлэсэн асуудал		

В. 1911, 1921 оны хувсгалын дараа авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг нийгмийн амьдралын хүрээгээр тодорхойлно уу.



Нийгмийн амьдралын хүрээ	1911	1921
Улс төр		
Эдийн засаг		
Соёл, боловсрол		

## 5. Бие дааж ажиллах дасгал, даалгавар

Сурвалжуудыг сайтар уншиж, даалгавруудыг гүйцэтгэнэ үү.

Сурвалж 1.

“Бүгд найрамдах Дундад Иргэн улсын нутаг дэвсгэр нь 22 муж, Ар, Өвөр Монгол, Түвэд, Хөх нуураас бүрдэнэ”.

(ДИУ-ын Үндсэн хуулийн 3-р зүйлээс)

Сурвалж2.

“Нэгд, байнгын хүн ам: хоёрт, тухайлан заагласан нутаг дэвсгэр: гуравт, төр засаг: дөрөвт, бусад улсуудтай харилцаанд орох чадамж”... бусад улсуудаар хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь улсыг тодорхойлох хүчин зүйл болохгүй”

(“Улсуудын эрх үүргийн тухай Монтевидеогийн Конвекц” –ийн 1, 3-р зүйлээс)

Сурвалж 3.

Хятадын Засгийн газар, Гадаад Монголын нийслэл Өргөөнд суугаа Хятадын элчин сайд Чэнь И-гээс Монгол хошуудын тэргүүдийн гарын үсэг бүхий өргөдөл бичиг хүлээн авсныг уламжилсан илтгэл авав. Уг өргөдөл бичигт монголчууд хэдэн жилийн өмнө далдуур үймүүлэгчдэд мэхлэгдэн автономийг тунхагласан боловч тэр цагаас хойш оросуудад дээрэлхүүлэн буйгаа нэн тодорхой өгүүлжээ... Тэд өргөдөл бичигтээ автономийг халж, Хятадын засгийн газрын ивээлд эргэн багтах хүслээ илэрхийлж байна. Чэнь И өргөдөл бичгийг зөвшөөрөхийг зөвлөөд, хэрэв (Хятадын засгийн газар) тээнэгэлзэх аваас боломжийг үүрд алдаж магадгүй хэмээн нэмж сануулсан байна. Засгийн газар уг саналыг зөвшөөрч, цалин, тэтгэмж амлаад, энэ зорилгоор 800.000 америк доллар гаргахаар шийдсэн тухай цахилгаан мэдээг Чэнь И-д илгээв.

(АНУ-ын “Нью Йорк Таймс сонины мэдээнээс 1919.10.31)

Сурвалж 4. Түүхэн зураг Сюй Шүжан монгол ноёдын хамт



Сурвалж 5.

Магнаг дээлтэй сайдууд гуай  
Манийгаа худалдаад гялайв уу.

Богц богц мөнгөөр

Богдоо худалдаад гялайв уу.

Дэнс дэнс мөнгөөр

Дэлхийгээ худалдсан сайдууд гуай

Хүүдий хүүдий мөнгөөр

Хүрээгээ худалдсан ноёдуудаа

(Ардын дууны хэсгээс)

Сурвалж 6.

“... Богд хаанаас Хятал элчин Чэнь И-г Монголын засгийн эрх баригчид лугаа нам нийлж автономит засгийг устгахаар хуйвалдав хэмээн битүүлэг буруушааж... бас ч ард олны зүгээс засгийн эрх баригчдаас Хятадад төрөө худалдахаар сэдэвлэв хэмээн цуу үг тасралтгүй сонсдох ба Хүрээний гол хүрдэн дор нэргүй бичиг наалдуулж шүүмжлэх зэргээр шар, хар олонхи ард автономит засгийг устгаж Хятадад нийлэхийг дурлах үгүй байдал илэрхий мэдэгджээ. Энэ нь Олноо өргөгдсөний 9 дүгээр оны (1919) зуны сүүл сарын үес болмой... тэр хооронд Сюй Шүжанаас ... мөн оны намрын сүүл сард... цэргийг авч Хүрээнд орж ирээд ирээд Монголын засгийн эрхийг барих ерөнхий сайд Бадамдорж нар лугаа уулзаж автономит засгийн газрыг устгахаар төлөвлөн хэлэлцэж буй чимээ сонсов”.

(Н. Магсаржав. “Монгол Улсын шинэ түүх” бүтээлээс)

А. Сурвалж 1, 2-д тулгуурлан хүснэгтийг гүйцээнэ үү.

№	Үндсэн санаа	Яагаад ийм заалт оруулах болов.
Сурвалж 1		
Сурвалж 2		

В. Сурвалж 3, 6-д тулгуурлан асуултад хариулна уу.

Сурвалж 3-т өгүүлснээр Чень И Засгийн газартаа Монголын эрх баригчид зээлээ барагдуулж, Хятадын засгийн газраас цалин, тэтгэмж авахын тулд татгалзахыг хүссэн гэж илгээжээ. Та түүний илтгэлтэй хэр санал нийлэх вэ?	
Монголын эрх баригчид автономит эрхээсээ татгалзсан шалтгааныг мэдэхэд Сурвалж 6 яагаад хэрэгтэй вэ?	

Чень И Хятадын засгийн газар Монголын автономийг устгалгүй тээнэгэлзэх аваас энэ боломжийг үүрд алдаж магадгүй хэмээн яаран сануулсан. Тэр яагаад энэ сануулгыг засгийн газартаа өгөв.	

C. Сурвалж 4, 5-д тулгуурлан тухайн үеийн талаар ямар дүгнэлт хийж чадах вэ?

---

---

---

---

---

---

---

---

D. 1920 оны эхээр Монголын автономит эрхийг яагаад устгасан бэ? Үүнд хариулах шалтгаануудыг жагсаан бич.

<hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/>
---

Таны бичсэн шалтгаануудаас Монголын автономит эрхийг устгахад аль нь хамгийн чухал байсан бэ? Хариултаа тайлбарла.

---

---

---

---

---

---

---

---

6. *Бие дааж ажиллах дасгал, даалгавар*

Өгөгдсөн сурвалжууд болон өөрийн мэдлэгт тулгуурлан тухайн үеийн нийгэм, улс төрийн нөхцөл байдлын талаар дүгнэж бичнэ үү.



Empty rectangular box for student response.

Бие даан судлах боломжтой хэрэглэгдэхүүн

- ❖ Теле хичээл <http://econtent.edu.mn/lessons/EBS/11rangj/tuuh/3610>
- ❖ Олноо өргөгдсөн төрийн түүх <https://www.youtube.com/watch?v=T6BNATwJQJA>
- ❖ Ё. Отгонбаяр “Тусгаар тогтнолын товчоон” <https://www.youtube.com/watch?v=veiTz9wyzUA>
- ❖ Тусгаар Монгол Улс баримтат кино <https://www.youtube.com/watch?v=IE0BlonNUQw>
- ❖ 1921 оны хувьсгал эрдэмтдийн үзэл бодол <https://www.youtube.com/watch?v=js7M9O-vael>